



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

“Хангарьд-2015” спорт наадам зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын Ажлын албаны ажилтнуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг “Хангарьд” спорт наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч	Ц.Алтанцацрал	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
Гишүүд	Ж.Лхагвасүрэн	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
	Б.Батхуяг	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
	Ц.Содхүү	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
	Ц.Ганболд	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
	М.Эрхэмбаяр	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч
	Ж.Ганбат	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Зохион байгуулалтын хэлтсийн дарга
	Т.Уламбаяр	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн дарга

Р.Очирпүрэв

Дүүргийн Засаг даргын дэргэдэх
Биеийн тамир спортын хорооны
дарга

Э.Анхтуяа

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Ажлын албаны ня-бо

2. “Хангарьд” спорт наадмыг 2015 оны 04 дүгээр сарын 23-наас 26-ны өдрүүдэд бэлтгэл зохион байгуулалтыг сайтар ханган зохион байгуулахыг Ажлын хэсэг /Ц.Алтанцацрал/-т даалгасугай.

3. Спорт наадамд оролцох баг тамирчдыг бэлтгэн, амжилттай оролцуулахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Спорт хамтлаг /Г.Уламбаяр/-т үүрэг болгосугай.

4. Спорт наадам зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр зүйлийн 1.11 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг мэдээ мэдээллээр хангах зорилгоор 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр нэгдсэн сургалт зохион байгуулахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.
2. Сургалтын удирдамж, хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
3. Сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал /-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын
25-ны өдрийн 29 дүгээр тогтоолын хавсралт



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн
нэгдсэн сургалт зохион байгуулах удирдамж, хөтөлбөр

Зорилго: Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг мэдээ мэдээллээр хангахад оршино.

Хугацаа: 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 9³⁰ цагт “Энхийн төлөө цогцолбор”-т зохион байгуулна.

Зохион байгуулагч: Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба

Хамрах хүрээ: Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын ажлын албаны ажилтнууд.

Хамтран ажиллах байгууллага: Дүүргийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир спорт хороо

ХӨТӨЛБӨР:

8 ³⁰ -9 ⁰⁰	Чингэлтэй дүүргийн үүднээс “Энхийн төлөө цогцолбор” руу хөдөлнө.
9 ³⁰ -9 ⁴⁰	Нээлт /Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Бат-Эрдэнэ/
9 ⁴⁰ -10 ²⁰	Шилэн дансны тухай хуулийн талаарх мэдээлэл /Монгол Улсын Сангийн яам, Төрийн сангийн газрын мэргэжилтэн/
10 ²⁰ -11 ⁰⁰	Газар өмчлөлийн ажлын тухай /Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Газар өмчлөлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Шижир/
11 ⁰⁰ -11 ²⁰	Цайны завсарлага /Энхийн төлөө цогцолборын заал/
11 ²⁰ -13 ²⁰	Оюунлаг удирдагч, Оюуны гялбаа /Эрдмийн Их сургуулийн хүндэт Доктор, Илтгэх эрдэм хүрээлэнгийн тэргүүн, Уран илтгэгч Б.Гэрэл/
13 ³⁰ -14 ³⁰	Үдийн цай /Энхийн төлөө цогцолборын хоолны заал/
14 ³⁰ -16 ³⁰	Спорт уралдаан тэмцээн /Дүүргийн Биеийн тамир спорт хороо/
16 ³⁰ -17 ³⁰	Чөлөөт цаг
17 ³⁰ -18 ³⁰	Оройн хоол
18 ³⁰	Улаанбаатар хот руу хөдлөх



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

**Хороодын Иргэдийн Нийтийн Хурлыг
чадавхжуулах сургалт зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр зүйлийн 1.12 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг анхан шатны нэгжид төлөвшүүлэх, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилгоор хороодын Иргэдийн Нийтийн Хурлыг чадавхжуулах сургалтыг 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

2. Сургалтын хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

3. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100067
Төлөгчдийн хурал 2015

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын
25-ны өдрийн 30 дугаар тогтоолын хавсралт



Хороодын Иргэдийн Нийтийн Хурлыг
чадавхжуулах сургалтын хөтөлбөр

Сургалт: 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10⁰⁰ цагт “Бишрэлт” ХХК-ийн Хурлын танхимд зохион байгуулагдана.

- | | |
|------------------------------------|---|
| 09 ⁵⁰ -10 ⁰⁰ | Бүртгэл |
| 10 ⁰⁰ -10 ⁰⁵ | Нээлт
/Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Д.Бат-Эрдэнэ/ |
| 10 ⁰⁵ -12 ⁰⁵ | “Иргэдийн Нийтийн Хурлын чиг үүрэг, хэрэгжүүлэх арга зам”
сэдэвт сургалт
/Монголын нутгийн удирдлагын холбооны дэд тэргүүн
Г.Маналжав/ |
| 12 ⁰⁵ -12 ³⁰ | Дүүрэг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар
хийгдэж буй ажил, 2015 онд хэрэгжих төсөл хөтөлбөр, цаг
үеийн асуудлаар мэдээлэл хийх
/Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
Ж.Эрдэнэбат/ |
| 12 ³⁰ -12 ⁵⁵ | Асуулт, хариулт |
| 12 ⁵⁵ -13 ⁰⁰ | Хаалт |
| 13 ⁰⁰ -14 ⁰⁰ | Өдрийн хоол |



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.2 дахь заалт Хорооны салбар зөвлөлийн дарга нар сар бүрийн 25-ны дотор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлынхаа тайланг дүүргийн салбар зөвлөлд ирүүлнэ гэснийг 20-ны дотор гэж өөрчилсүгэй.

2. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Хороодод ажиллах хэв журмын урамшилтай эргүүлийн ажиллах журам”-ын 3.2 дахь заалт Эргүүл нь ажлаа батлагдсан ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөр дүгнүүлэн сар бүрийн 25-ны дотор ажил дүгнэсэн үзүүлэлтийг илтгэх хуудсын хамт дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд ирүүлнэ гэснийг 20-ны дотор гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 13, 25 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дүүргийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга /С.Туяа/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100059



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнасугай.

2. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын
25-ны өдрийн 32 дугаар тогтоолын хавсралт



Шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
“Чандмань одон”-гоор			
1.	Д.Өлзийбаяр	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	ПЕ73041707
“Хүндэт өргөмжлөл”-өөр			
1.	М.Лхагвасүрэн	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч	РЮ73031468